

## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**Аудитын сэдэв:** Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах

**Аудитын код:** ХЭА-2024/14-22-ШТА-НА

**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:** Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

**АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ:** Нам, эвсэл нь дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын 67 тайланг үнэн зөв тайлагнасан байна.

**Тайланг хүргүүлсэн этгээд:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу хандивын тайланг баталгаажуулсан дүгнэлтийг 11 нам, 1 эвсэлд хүргүүлэв.

Хаяг: Чингис хот,  
АЗДТГ-ын байр

**Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:**  
Тайланг Хэнтий аймаг дахь ТАГ-ын <http://audit.mn/> веб сайтаас үзнэ үү.

### **Аудитын харилцан хамаарал:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7, 37.12 дахь заалтын дагуу аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргав.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох Монгол ардын намын 19, Ардчилсан намын 19, Иргэний хөдөлгөөний намын 19, Хүн намын 2 хороо, Иргэний зориг ногоон нам 1, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам 1, Иргэдийн оролцооны нэгдэл нам 1, Хөгжлийн хөтөлбөр нам 1, Үнэн ба зөв нам 1, Шинэ нам 1, Хүний төлөө нам 1, Үндэсний эвсэл 1 /Монгол үндэсний ардчилсан нам, Монголын ногоон нам/, нийт 67 хандивын тайланг дүгнэлт гаргуулахаар хуулийн хугацаанд ирүүлсэн байна. Үүнд:

1. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Монгол ардын нам, Ардчилсан нам, Иргэний хөдөлгөөний нам, Хүн нам, Иргэний зориг ногоон нам, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам, Иргэдийн оролцооны нэгдэл нам, Хөгжлийн хөтөлбөр нам, Үнэн ба зөв нам, Шинэ нам, Хүний төлөө нам, Үндэсний эвсэл /Монгол үндэсний ардчилсан нам, Монголын ногоон нам/, нийт 11 нам, 1 эвсэл хандивын тайлангаа ирүүлсэн байна.
2. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох сумдын Монгол ардын намын 18 хороо , Ардчилсан намын 18 хороо, Иргэний хөдөлгөөний намын 18 хороо, Хүн намын 1 хороо, нийт 4 намын хороодоос 55 хандивын тайлангаа ирүүлсэн байна.

### **Аудитын зорилт:**

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэгдсэн.

### **Аудитын хамарсан хүрээ:**

Хандивын тайлангаа хянуулж, баталгаажуулахаар ирүүлсэн нам, эвслийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тайлагнасан хандивын дансны хуулга, тухайн нам, эвсэлд хамаарах мэдээлэл хуулийн этгээдийн талаарх холбогдох мэдээлэл, лавлагаа зэрэг шаардлагатай эх сурвалжийг ашигласан.

Аудитад сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл болон Арилжааны банкнууд, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудыг хамрууллаа.

### **Аудитын үр дүн:**

Хэнтий аймгийн Батширээт сумын Монгол ардын намын хороо нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны хандивын тайланд тусгасан нийт 0.2 сая төгрөгийн хандивыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар тавьсан шаардлагын дагуу хүлээн авсан байна.

Монгол ардын намын 18 хороо, Ардчилсан намын 19 хороо, Иргэний хөдөлгөөний намын 19 хороо, Хүн намын 2 хороо, Иргэний зориг ногоон нам, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам, Иргэдийн оролцооны нэгдэл нам, Хөгжлийн хөтөлбөр нам, Үнэн ба зөв нам, Шинэ нам, Хүний төлөө нам, Үндэсний эвсэл нам /Монгол үндэсний ардчилсан нам, Монголын ногоон нам/, нийт 11 нам, 1 эвслийн 66 тайланд 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

Хэнтий аймгийн Батширээт сумын Монгол ардын намын хороо 1 иргэнээс 0.2 сая төгрөгийн хандивыг орлого авч, үнэн зөв тайлагнасан байна.

**Аудитын гол дүгнэлт:**

- ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ ДҮГНЭЛТ ГАРГУУЛАХААР ИРҮҮЛСЭН 11 НАМ, 1 ЭВСЭЛ НЬ ХАНДИВЫН 67 ТАЙЛАНГ ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНАСАН БАЙНА.
- БАТШИРЭЭТ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 1 ИРГЭНЭЭС АВСАН 0.2 САЯ ТӨГРӨГИЙН ХАНДИВ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ЖУРАМТАЙ НИЙЦЭЖ БАЙНА.

**Гурав. Баталгаажуулалт:**

Хянасан:

Дарга, Тэргүүлэх аудитор

Ж.Ганбаатар

Аудитын менежер

Д.Оюунтуяа

Бэлтгэсэн:

Аудитор

Н.Туяа

Аудитор

Б.Хуланхатан